

## Нийтийн биеийн тамир-идэвхтэй хөдөлгөөн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээнүүд

Монгол улсын засгийн газрын 05 тогтоолын дагуу жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Өвлийн агаар-Өлчир бие” сэдэвт “Хаялга нуурын жавар” өдөрлөгийг 2019 оны 01 сарын 12-нд Хаялга нуурын хөвөөнд зохион байгууллаа. Өдөрлөгийн арга хэмжээг спортын 3-н төрлөөр зохион байгуулж, ний 27 байгууллагын 500 гаруй албан хаагч ажилчид, иргэд оролцлоо. Өдөрлөгийн нээлтийн арга хэмжээнд Аймгийн ИТХ-ын дарга Г.Батзам, Аймгийн Засаг дарга Г.Батсуурь, Аймгийн Засаг даргын орлогч Ш.Билэггүмбэрэл, 3-н сумын Засаг дарга нар оролцсон.

Өдөрлөгийн **Мөсний шагай харвааны** тэмцээнд 1-р байранд н.Ариун-Эрдэнэ дарга Нэгдсэн эмнэлэг, 2-р байранд Б.Отгончимэг даргатай Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, 3-р байранд н.Нямбаатар даргатай Цахилгаан дамжуулах сүлжээ, **Оновчтой цохилтын** тэмцээнд 1-р байранд Э.Тамир дарга Шүүх шийдвэр гүйцэтгэх газар, 2-р байранд Ш.Отгонжаргал захиралтай Политехник коллеж, 3-р байранд Цэцгээ захиралтай 1 дүгээр сургууль, **“Хөгжилтэй буухиа”** тэмцээнд Баянтал сумын 4-р цэцэрлэг, 2-р байранд н.Дамдинсүрэн дарга Онцгой байдлын газар, 3-р байранд Бат-Очир дарга Цагдаагийн хэлтэс, **“Говьсүмбэр-2040”** олимпын билэгдэл бүтээх тэмцээнд 1-р байранд н.Ариун-Эрдэнэ дарга Нэгдсэн эмнэлэг, 2-р байр Татварын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Авто тээврийн төв, Улсын бүртгэлийн хэлтэсүүдийн нэгдсэн баг, 3-р байранд Аймаг, сумдын ИТХ-ын төлөөлөгчдийн багийн тус тус байранд орлоо. Өдөрлөгт ач холбогдол өгч идэвхтэй оролцсон Албан байгууллагууддаа талархал илэрхийлье.



Волейболын чойр хөгжлийн DREAM ЛИГ – 2019 тэмцээн 2019 оны 02 дугаар сарын 23-наас 03 дугаар сарын 10 хүртэл гурван 7 хоногийн турш зохион байгуулагдаж дүнгээ гаргалаа. Тэмцээнд эрэгтэй 5, эмэгтэй 8 багийн нийт 140 гаруй тамирчид оролцон өрсөлдөж аваргууд тодорлоо. Тэмцээний үеэр DREAM лигийн бүх оддыг тоглолтыг ДЦС-4 ТӨХК-ны Эрчим клубтэй нөхөрсөг тоглолт хэлбэрээр зохион байгуулсан. Тэмцээний эмэгтэйчүүдийн дэд аварга багаар А.Азбаяр эзэнтэй см Б.Баттуул ахлагчтай БЗӨБ ЦТС ТӨХК говьсүмбэр сабарын Эрчим баг Аварга багаар П.Эрдэнэзаяа эзэнтэй см З.Отгонтуяа ахлагчтай Бизнес хөгжил баг, эрэгтэйчүүдийн дэд аварга багаар А.Азбаяр



эзэнтэй см Э.Оюунболд ахлагчтай БЗӨБ ЦТС ТӨХК говьсүмбэр салбарын Эрчим баг Аварга багаар Б.Төгсбаяр эзэнтэй см Х.Дагва ахлагчтай УБТЗ Чойр зангилааны Ганзам баг

DREAM лигийн шилдэг тамирчид

шилдэг холбогчоор эмэгтэй багаас эмэгтэйчүүдийн холбоо багийн А.Ану

шилдэг холбогчоор эрэгтэй багаас Ганзам багийн Б.Эрдэнэбат

шилдэг довтлогчоор эмэгтэй багаас Бизнес хөгжил багийн Н.Ган-Эрдэнэ

шилдэг довтлогчоор эрэгтэй багаас Эрчим багийн П.Молор-Эрдэнэ

шилдэг тэгш тоглогчоор эмэгтэй багаас Эрчим багийн Б.Баттуул

шилдэг тэгш тоглогчоор эрэгтэй багаас Ганзам багийн А.Ану





Монголын “Эх орончдын өдөр”, МАН-ын 98 жилийн ойд зориулсан сагсан бөмбөгийн тэмцээнийг 03 сарын 2,3-ны Биеийн тамир, спортын спорт зааланд амжилттай зохион байгуулагдаж эрэгтэй 15 баг, эмэгтэй 10 баг нийт 25 багийн 200 гаруй тамирчид оролцсон. эрэгтэй 1-р байранд Анхбаяр ахлагчтай Тандер баг, 2-р байранд Батхишиг ахлагчтай Элит баг, 3-р байранд Цагдаагийн хэлтэсийн баг, эмэгтэй 1-р байранд Н.Ариунаа ахлагчтай Баянтал сумын баг тамирчид 2-р байранд Энхсүрэн ахлагчтай Шивээ-Овоо ХК, 3-р байранд Чойр зангилааны хамт олон орсон.



Нийгмийн бодлогын хэлтсийн харъяа байгууллагуудын хооронд жил болгон зохион байгуулж буй шилжин явах цомын төлөөх спортын 10-н төрлийн тэмцээнийг 04 сарын 13-нд Биеийн тамир спортын зааланд зохион байгууллаа. Тэмцээнд нэгдсэн дүнгээр 1-р байранд Цэнджав дарга Боржигин чуулга, 2-р байранд Ш.Отгонжаргал захиралтай Политехникийн коллеж, 3-р байранд Б.Баттогтох Ерөнхий боловсролын сургуулиудын баг орсон. Төрөл тус бүрт шилдэг тамирчдыг шалгарууллаа.





Олон улсын гэр бүлийн өдрийг угтан зохион байгуулсан Волейболын спортын дэд мастер, улсын 1-р зэргийн шүүгч О.Одцэрэнгийн нэрэмжит волейболын гэр бүлийн тэмцээн амжилттай зохион байгуулагдаж өндрөллөө. Тэмцээнд Нямаагийн гэр бүл, Одцэрэгийн гэр бүл, Пүрэвдоржийн гэр бүл, Цэдэвийн гэр бүл, Дамбийгийн гэр бүл, Амгаагийн гэр бүл, Доржбатын гэр бүл, Ёндонгийн гэр бүл, Лувсандоржийн гэр бүл нийт 9 гэр бүлийн 60 гаруй тамирчид оролцон өрсөлдлөө.

- 1-р байранд Идэржавхлан ахлагчтай Доржбатын гэр бүл
- 2-р байранд Баярмаа ахлагчтай Пүрэвдоржийн гэр бүл
- 3-р байранд Оюунболд ахлагчтай Ёндонгийн гэр бүл
- 4-р байранд Баянжаргал ахлагчтай Амгаагийн гэр бүл тус тус байр эзэллээ.



тэмцээнд оролцсон нийт тамирчдаас хамгийн өндөр настай тамирчин мөн өсөх ирээдүйтэй тамирчдыг шалгаруулсанаас өндөр настай тамирчнаар Л.Ёндон, өсөх ирээдүйтэй тамирчнаар Б.Батжавхлан нар шалгарлаа. Тэмцээнд маань оролцохоор монгол орны зүүн хязгаар Дорнод аймгаас ирсэн Амгаагийн гэр бүлийн тамирчин Спортын мастер Б.Есөнтөмөр нар шалгарсан.



Аймгийн засаг даргын 2019 оны 05 сарын 08-ны А/18/4 дугаар тоот захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Албан байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэдэд Өглөөний дасгалын ач холбогдолыг сурталчилан таниулах, хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлж, хүн амыг эрүүл, стрессгүй, амьдралын хэв маяг, дадлыг бий болгох үүднээс “Өглөөний агаар-Идэвхтэй хөдөлгөн” сэдэвт өглөөний гүйлт 2019 оны 05 сарын 09-ны өглөөний 07 цагт “Сүмбэр гарден” амралт, соёлын хүрээлэнд эхлэн 05 саарын 22-ны байдлаар 10 байгууллагын давхардсан тоогоор 624 албан хаагч, иргэн хамрагдаад байна.



Эрүүл зүрх. Эрүүл хөдөлгөөн Эрүүл ёс зүй. Төсөлийн хүрээнд байгууллагын дарга нарын бооцоот хөгжөөнт тэмцээн болон зүрх судасны үйл ажиллагаа болон зүрх судасны кабинет говьсүмбэр аймагт хэрэгтэй юу зэрэг сургалтууд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд Ундармаа ахлагчтай Эрүүл хөдөлгөөн баг 1.р байранд орлоо. Урилгаар ирж сургалтанд хамрагдан идэвхитэй хөдөлгөөнөө хуваалцсан.





Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас аймгийн Залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийн хүрээнд Биеийн тамир спортын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газруудтай хамтран 2019 оны 06 сарын 22-ны өдөр өсвөр үе, залуучуудыг идэвхитэй хөдөлгөөнд уриалах, эрүүл амьдралын хэв маягийг сурталчилах, байгаль орчноо цэвэрлэн, хайрлан хамгаалах үзэл санааг өсвөр үе, залуучуудад төлөвшүүлэн дэлгэрүүлэх, алхалт, явган аяллыг хөгжүүлэх зорилгоор “ЭХ БАЙГАЛИА ХАМГААЛЖ, ИДЭВХИТЭЙ АМЬДАРЦГААЯ” явган аяллыг зохион байгууллаа. Аялалд аймгийн ШШГГ 425-р ангийн баг хамт олон, Улсын бүртгэлийн хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Биеийн тамир спортын газар, Ахмадын хороо, Өсвөр үеийн хүүхэд залуусын баг, иргэдийн баг нийт 5 багийн 56 хүн хамрагдсан байна.



Засгийн газрын 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, хөдөөгийн малчин залуучуудын бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх, спортоор чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 2019 оны 9-р сарын 18-нд Говьсүмбэр аймгийн 4-р багийн төвд сүмбэр сумын хөдөөгийн 3-р багийн залуучуудын Хөдөөгийн баясгалан өдөрлөгийг амжилттай зохион байгуулсан. 3-н багийн 150 гаруй малчин залуучууд оролцлоо. Өдөрлөгөөр холимог волейбол, олс таталт, хөгжилтэй буухиа, Уян хатан, хөдөөгийн хүчтэн, АХА асуулт хариулт зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулсан байгуулсан.

Олс таталтын тэмцээнд

1-р байранд Ц.Гантулга ахлагчтай 4-р багийн 1-р баг

2-р байранд Ж.Цогтсайхан ахлагчтай 4-р багийн 2-р баг

3-р байранд Ц.Шинэбаяр ахлагчтай 6-р багийн 2-р баг

Холимог волейболын төрөлд:

1-р байранд О.Ням ахлагчтай 5-р баг

2-р байранд Ч.Сүхтулга ахлагчтай 6-р баг

3-р байранд Л.Батзаяа ахлагчтай 4-р баг

Хөгжилтэй буухиа төрөлд:

1-р байранд Ч.Сүхтулга ахлагчтай 6-р баг

2-р байранд Д.Даваахүү ахлагчтай 4-р баг

3-р байранд Д.Отгонтуяа ахлагчтай 4-р баг

Уян хатанд

1-р байранд Отгонтуяа

2-р байранд Баярмаа

3-р байранд Халиун

Хөдөөгийн хүчтэн

1-р байранд Д.Даваахүү- 4-р баг

2-р байранд Амартөр 4-р баг

3-р байранд Ган-Очир- 6-р баг

Багийн нэгдсэн дүнгээр Т.Одгэрэл даргатай 4-р багийн малчин залуучууд шилжин явах цом, мөнгөн шагналаар шагнагдсан. Энэхүү спортын өдөрлөгийн арга хэмжээнд хамтран ажилласан Боловсрол соёл урлагийн газар, Сүмбэр сумын ЗДТГ, Боржигин чуулга, Номын сан, Музей, Багачууд хөгжил төрийн бус байгууллагууд хамтран зохион байгууллаа.







"Эрүүл зүрх- Эрүүл хөдөлгөөн Эрүүл ёс зүй" төслийн хүрээнд зохион байгуулж буй "ГОВЬСҮМБЭР-2019" нийтийг хамарсан марафон гүйлтийн тэмцээнийг 2019 оны 09 сарын 28-ны амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд нийт 50 гаруй оролцогч оролцлоо.

Эрэгтэй :

- 1-р байранд Хан-уул дүүргийн онцгой байдлын газрын тамирчин н.Цогтбаатар
- 2-р байранд Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газрын тамирчин н.Мөнхчулуун
- 3-р байранд Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газрын тамирчин М.Бат-Очир
- 4-р байранд Говьсүмбэр аймгийн Шүүх шийдвэр гүйцэтгэх газрын тамирчин н.Бямба-Эрдэнэ
- 5-р байранд Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэсийн тамирчин Б.Бат-Оргил

Эмэгтэй:

- 1-р байранд Говьсүмбэр аймгийн Төмөр замын дэлгүүрийн тамирчин Д.Ичинхорлоо



2-р байранд Говьсүмбэр аймгийн Шүүх шийдвэр гүйцэтгэх газрын тамирчин н.Баярцэцэг  
3-р байранд Говьсүмбэр аймгийн Шүүх шийдвэр гүйцэтгэх газрын тамирчин н.Солонго



4-р байранд Говьсүмбэр аймгийн Шүүх шийдвэр гүйцэтгэх газрын тамирчин Н.Амарзаяа

5-р байранд Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газрын тамирчин н.Алтантуул нар байранд орлоо.

Аймгийн засаг даргын 2019 оны 05 сарын 08-ны А/18/4 дугаар тоот захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Албан байгууллага, аж ахуйн нэгжийн спорт хамтлагийн ахлагч нарт “Дасгал хөдөлгөөн” талаар мэдлэг олгох, дадлагийн сургалтын 2019 оны 10 сарын 18,19-нд БТСГ-ын спорт зааланд зохион байгууллаа. Сургалтыг үндэсний Биеийн тамирын дээд сургуулийн Гимнастикийн багш Ч.Лхамсүрэн удирдан зохион явуулсан.








хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр", Монгол улсын засгийн газрын дэмжлэгтэйгээр Дэлхийн банк, Швейцарийн хөгжлийн агентлагын санхүүжилттэй хэрэгжиж байгаа "НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ" төслийн 2 дахь шат "ЭРҮҮЛ ЗҮРХ-ЭРҮҮЛ ХӨДӨЛГӨӨН-ЭРҮҮЛ ЁС ЗҮЙ" дэд төслийн хүрээнд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, нийтийн биеийн тамирыг сурталчилан таниулж, эрүүл чийрэг бие бялдарыг цогцлоход иргэн, аж ахуйн нэгж байгууллага бүрийг оролцуулан идэвхижүүлэх, орон нутгийн ард иргэдийг аливаа төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажлын байранд идэвхитэй дасгал хөдөлгөөн хийх зөв дадалтай болгох зорилгоор зохион байгуулсан "ЭРҮҮЛ БИЕ-САРУУЛ УХААН-ЭРҮҮЛ ХӨДӨЛГӨӨН 60" дасгал хөдөлгөөний тэмцээн амжилттай зохион байгуулагдлаа.

Гимнастикийн тэмцээнд нийт 14 багийн 224 оролцогчид оролцсон бөгөөд

- 1 дүгээр байранд БОРЖИГОН ЧУУЛГА шалгарч өргөмжлөл, 800,000 төгрөг,
- 2 дугаар байранд "ШИВЭЭГОВЬ СУМ"-ын баг шалгарч өргөмжлөл, 500,000 төгрөг
- 3 дугаар байранд "ТӨМӨР ЗӨМЫН АХМАД"-ын баг шалгарч 300.000 төгрөг,
- Тусгай байранд цэцэрлэгийн баг өргөмжлөл, 100,000 төгрөгөөр шалгарч шагнууллаа.





Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд жил болгон зохион байгуулагддаг “СПОРТ”-ын арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон асран хамгаалагч нарын дунд Аймгийн Засаг даргын тамгын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Биеийн тамир спортын газар болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Өөдрөг зөвлөл” холбоо хамтран 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгууллаа.

Тус арга хэмжээг нээж Нийгмийн бодлогын хэлтсийн дарга С.Уранцэцэг мэндчилгээ дэвшүүлсэн бөгөөд арга хэмжээнд нийт 40 гаруй иргэд даам, суугаа волейбол, ширээний шагай, олс таталт, гар барилдаан, хонхот теннис / эрэгтэй, эмэгтэй / зэрэг 6 төрлийн тэмцээнээр өөрсдийн авхаалж самбаа, ур чадвараа уралдуулан оролцож, тэмцээн тус бүрт тэргүүн, дэд, гутгаар байр эзлэн өргөмжлөл, мөнгөн шагналын эзэд боллоо.







"Усаар чийрэгжье" сэдэвт аюул өдөрлөг 2019 оны 11-р сарын 17-ны өдөр усан спорт сургалтын төвд амжилттай зохиогдлоо. Тус тэмцээний өсвөрийн төрөлд 6-17 насны 50 гаруй тамирчин, насанд хүрэгчдийн төрөлд 20 гаруй тамирчид тус тус хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

Тэмцээн 6-8 нас эрэгтэй эмэгтэй мэлхий сэлэлт 50м, 9-13 нас эрэгтэй эмэгтэй мэлхий сэлэлт 50м, 14-17 нас эрэгтэй эмэгтэй өврөөр даллах сэлэлт 50м, насанд хүрэгчид 35 аас доош насны тамирчид эрэгтэй араар даллах 50м, эмэгтэй мэлхий сэлэлт 50м, 35 аас дээш насны эрэгтэй өврөөр даллах сэлэлт 50м, эмэгтэй мэлхий сэлэлт 50м зайнуудад тус тус аваргаа шалгарууллаа.

Мөн нас насны тамирчдаас бүрдсэн 4\*25м буухиа сэлэлтээр 10-н баг өрсөлдөж аваргаа шалгарууллаа.



## Үндэсий спортын арга хэмжээнүүд

Говьсүмбэр аймгийн үндэсний бөхийн холбоо, аймгийн БТСГазар хамтран Хөдөө орон нутагтаа тогтвортой ажиллаж амьдран, ард түмнээ баясгаж байгаа хөдөөгийн бөхчүүд, залуу бөхчүүдийг тодруулах, бие биенээсээ харилцан суралцах, бэлтгэл сургуулилтаа тогтмолжуулах боломж олгох, тэдний барилдааны амжилтыг дээшлүүлэх, бөхчүүдээ тал бүрээр дэмжихэд орон нутгийн удирдлага, байгууллага, хамт олны анхаарлыг хандуулах зорилгоор үндэсний бөхийн аварга шалгаруулах багийн барилдааныг 2019 оны 01-р сарын 20-нд БТСГазрын зааланд амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээний нээлтэнд Аймгийн ИТХ-ын дарга Г.Батзам, аймгийн үндэсний бөхийн холбооны тэргүүн Ж.Насанбат, аймгийн Засаг даргын орлогч Ш.Билэггүмбэрэл нар оролцлоо.



Үндэсний бөхийн аварга шалгаруулах багийн барилдаанд ХОХБТХэлтэсийн харъяа агентлагууд /Хүнс хөдөө аж ахуйн газар, Цаг уур орчны шинжилгээний төв/ 5-р сургууль, Төрийн банкны хамтарсан "ШАР АРСЛАН" баг, Аймгийн цагдаагийн хэлтсийн "ШОНХОР" баг, Төмөр замын баг, Шивээ овоо уурхайн "Уурхайн хүчтэн" баг, Сүмбэр сумын 5-р баг "Чойрын богд" баг, Сүмбэр сумын 3-р баг, Баянтал сумын баг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын баг, Цахилгаан түгээх сүлжээ нийт 9 багийн 54 бөхчүүд уран мөхийг



уралдуулан барилдсанаас Багийн дүнгээр Тэргүүн байранд Шивээ овоо ХК-ын Уурхайн хүчтэнгүүд баг шалгарч алтан медал, шилжин явах цомын эзэд боллоо. 2-р байранд Улаанбаатар төмөр замын харъяа Чойр зангилааны баг, 3-р байранд Сүмбэр сумын 3-р багийн Найрамдал баг шалгарсан. Хувийн дүнгээр Тэргүүн байранд Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын харъяат аймгийн арслан М.Мөнхбаатар 9 даваатайгаар, 2-р байранд Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын харъяат аймгийн заан А.Амартөр, 3-р байранд Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын харъяат аймгийн харцага Л.Тулга нар шалгарлаа.

Билгийн тооллын ХҮИ жарны “Урвуулагч” хэмээх ШОРООН ГАХАЙ жилийн сар шинийн баярт зориулсан улс, аймаг, сумын алдар цолтой хүчит бөхийн барилдаан, нийтийн монгол бөхийн барилдаан, хуурнин шуугигч өвсөрийн бөхийн барилдаануудыг 2019 оны 01 сарын 27-ны өдөр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Сүмбэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газраас хамтран зохион байгууллаа. Улс, аймаг, сумын цолтой бөхийн барилдаанд Сүмбэр сумын харъяат, “Кюкшүзан хөгжил сан”-ийн бөх, аймгийн арслан Энхтөрийн МӨНХБААТАР түрүүлж, Төв аймгийн Баяндэлгэр сумын харъяат, улсын өсөх идэр начин Чулуунбаатарын БАТЧУЛУУН үзүүрлэж, Дорноговь аймгийн Айраг сумын харъяат, аймгийн арслан Мөнхжаргалын БЯМБАДОРЖ, Өмнөговь аймгийн Номгон сумын харъяат, аймгийн харцага Мандахын АДЪЯАХҮҮ нар шөвгөрсөн байна. Тус барилдаанд үзэгч түмний уран хурц барилдаанаараа баясгасан Сүмбэр сумын харъяат, аймгийн заан Александрын АМАРТӨРД “Уран барилдаантай” бөхийн шагналыг олголоо.

Нийтийн монгол бөхийн барилдаанд Хүнс, хөдөө аж ахуйн газрын бөх Э.Түвшинзаяа түрүүлж, Сүмбэр сумын 5 дугаар багийн залуу бөх Х.Гантулга үзүүрлэж, их шөвөгт залуу бөх Э.Болд-Эрдэнэ, Г.Бямбадорж нар үлдэж, дунд шөвөгт залуу бөх н.Батсайхан, н.Жавхлантөгс, н.Мөнхбаяр нар шалгарч үлдсэн байна.





Говьсүмбэр аймгийн шагайн харвааны салбар холбооноос жил бүр зохион байгуулдаг Сар шинийн харвааг 02 сарын 17-нд БТСГ-ын спорт зааланд зохион байгуулагдсан. Энэ удаагийн тэмцээнд Улаанбаатар хот, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Төв гэсэн аймгуудын 27 багийн 216 гаруй харваач цэц сорилоо.



Говьсүмбэр аймгийн “Жахрай мэргэн” үндэсний сурын холбооноос жил бүр зохион байгуулдаг Сар шинийн харвааг 02 сарын 10-нд Төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулагдсан. Энэ удаагийн тэмцээнд Дорноговь, Говьсүмбэр аймгийн нийт 40 гаруй харваачид цэц сорилоо.

БТСГазар, аймгийн Шагайн холбоотой хамтран насанд хүрэгчдийн шагайн харвааны Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2019 оны 04 дүгээр сарын 06-нд Аймгийн Биеийн тамир, спортын газрын спорт зааланд амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд 9 байгууллагын 80 гаруй харваачид цэц мэргэнээ сорьж өрсөлдлөө.

Цуваа харваа

1-р байр: Улсын мэргэн Г.Ган-Эрдэнэ /Баянтал сум/

2-р байр: Аймгийн гоц мэргэн Б.Ганхүү /Баянтал сум/

3-р байр: Аймгийн гоц мэргэн Д.Зүмбэрэл /Чойр өртөөний “Ганзам” баг /  
Багийн харваа

1-р байр: Улсын мэргэн Б.Одсүрэн ахлагчтай Чойр өртөөний “Ганзам” баг

2-р байр: Залуу харваач О.Ганбат ахлагчтай Шивээ-Овоо ХК-ний баг

3-р байр: Аймгийн гоц мэргэн О.Дэлгэрбаяр ахлагчтай Баянтал сумын баг тамирчид тус тус шалгарлаа.



